



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 231

Улаанбаатар хот

Хөрөнгө, өр төлбөр бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713” төслийн хүрээнд бий болсон нийт 44,998,571,580.88 (дөчин дөрвөн тэрбум есөн зуун ерэн найман сая таван зуун далан нэгэн мянга таван зуун наян төгрөг наян найман мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгө, холбогдох өр төлбөрийг хавсралтад заасны дагуу аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Булган, Дундговь, Хэнтий, Хөвсгөл, Сүхбаатар аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Зээлийн хөрөнгөөр бий болсон үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох, бүртгэлд тусгах асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Үл хөдлөх хөрөнгийн доорх газрын эзэмших эрхийг холбогдох орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр дээр баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001126

14-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн
 ...281... дугаар тогтоолын хавсралт



АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР "ЗҮҮН ӨМНӨД ГОВИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХИЛИЙН ОЙРОЛЦОО СУУРИН ГАЗРУУДЫН ХӨГЖЛИЙН МОН-3713" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ (ТОВЧОО)

Д/д	Хөрөнгийн нэр	Нийт дүн (төгрөг)	Хүлээн авч бүртгэх орон нутгийн өмчит байгууллага	Сангийн яам, аймгийн Засаг даргатай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний ОГНОО
1	Булган аймгийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний ажлын хүрээнд бий болсон хөрөнгө	150,368,545.66	Булган аймгийн өмчит байгууллага	2019.08.29
	Дундговь аймгийн цэвэрлэх байгууламж	9,449,229,205.89		
	Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын цэвэрлэх байгууламж болон бусад ажил	1,939,828,243.31		
2	Машин механизм, багаж, тоног төхөөрөмж	848,070,622.82	Дундговь аймгийн өмчит байгууллага	2019.08.29
	Хэнтий аймгийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний ажлын хүрээнд бий болсон хөрөнгө	9,494,912,295.27		
3	Хэнтий аймгийн Бэрх сумын төвийн төвлөрсөн халаалтын систем	785,196,817.16	Хэнтий аймгийн өмчит байгууллага	2019.08.29
	Машин механизм, багаж, тоног төхөөрөмж	519,124,022.72		
	Бараа материал (Эргэлтийн хөрөнгө)	25,850,000.00		
4	Хөвсгөл аймгийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний ажлын хүрээнд бий болсон хөрөнгө	9,264,429,554.03	Хөвсгөл аймгийн өмчит байгууллага	2019.08.29
	Машин механизм, багаж, тоног төхөөрөмж	1,015,810,947.26		

Д/д	Хөрөнгийн нэр	Нийт дүн (төгрөг)	Хүлээн авч бүртгэх орон нутгийн өмчит байгууллага	Сангийн яам, аймгийн Засаг даргатай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний огноо
5	Сүхбаатар аймгийн төвийн цэвэрлэх байгууламж Машин механизм, багаж, тоног төхөөрөмж	10,429,913,360.11 1,075,837,966.65 44,998,571,580.88	Сүхбаатар аймгийн өмчит байгууллага	2019.08.29
Нийт дүн		(дечин дөрвөн тэрбум есөн зуун ерэн найман сая таван зуун далан нэгэн мянга таван зуун наян төгрөг наян найман мөнгө)		